



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/35

Пионер толгой

Г Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэнгэл багийн Өвөр нарийний Уулзвар гэх нутаг дэвсгэрт үхсэн тэмээнээс авч явуулсан дээж материалаас аймгийн мал эмнэлгийн лабораторийн 22-39 дугаартай шинжилгээний хуудасаар галзуу өвчин болох нь батлагдсан тул 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 03-ныг хүртэлх хугацаанд хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2. Өвчний тархалтыг хумих, тандалт судалгаа хийх зорилгоор голомтын бүсээс хүн, мал амьтан техник хэрэгслийн орох гарах, дамжин өнгөрөх хөдөлгөөнийг дээрх хугацаанд хориглосугай.


3. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар авч хэрэгжүүлсэн ажлын дүн мэдээг нэгтгэж өдөр бүр сумын Онцгой комисст мэдээллэхийг мал эмнэлгийн тасгийн дарга (Э.Хас-Очир)-д хариуцуулсугай.

4. Иргэд, малчид, мал бүхий иргэдийг цаг үеийн мэдээллээр хангаж хязгаарлалтын дэглэмийг чанд сахиулж хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга /Б.Лувсанширэв/-д даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Шуурхай штабын дарга (Р.Гантулга)-д үүрэг болгосугай.

8. Хязгаарлалтын дэглэм тогтоосонтой холбоотой гарах зардлыг хавсралтаар баталж, гамшгаас хамгаалах зардлаас гарган зарцуулахыг Тамгын газрын дарга (Р.Гантулга), нягтлан бодогч (Б.Дэлгэрдалай) нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.ГАНТУЛГА

642101161

Б/2022 он/Засаг дарга/Захирамж